



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/366

Чингис хот

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", 29.3. Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам" -ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн системчлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын мэргэжилтэн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн дарга

2. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журмын хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/33 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ